



**МОНГОЛ УЛСАД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ:
ЗОРИЛТОТ БҮЛГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ**

(Судалгааны тайлан)

Гүйцэтгэгч: *Судлаач Б.Одонгэрэл*

Улаанбаатар хот

2017 он

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ОНЦЛОГ	7
1.1. Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны талаарх Монгол Улсын хууль эрх зүйн орчин.....	7
1.2. Монгол Улсын хууль зүйн туслалцааны тогтолцоо, үүсэл хөгжил.....	8
1.3. Монгол Улсад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн нөхцөл байдал	10
1.3.1. Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох нь	13
1.3.2. Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхэд тулгамдаж буй асуудал	21
ХОЁР. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БА ХҮНИЙ ЭРХ: ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ, СТАНДАРТ	24
ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА	24
2.1. Олон улсын хүний эрхийн үндсэн эх сурвалж буюу үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нь	24
2.2. Хууль зүйн туслалцаа үзүүлж буй гадаад орнуудын туршлага	26
2.2.1. БНХАУ болон ОХУ-ын эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй туршлага	27
2.2.2. БНСУ, Япон улсын эрх зүйн орчин, практик	29
ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ИРГЭНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦҮҮЛЭН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖООР ХАНГАХ НЬ	30
3.1. Монгол Улсад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал ба олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн орчинг сайжруулах буюу хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах нь	30
ДҮГНЭЛТ	35
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	37
ЭХ СУРВАЛЖ	40

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

№	Товчилсон нэр томьёо	Үгсээр
1	НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
2	ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
3	ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
4	ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
5	МХХ	Монголын хуульчдын холбоо
6	ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
7	ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт
8	ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт
9	ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
10	ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагаа
11	ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

УДИРТГАЛ

Үнэ төлбөргүй буюу төрөөс санхүүжүүлсэн хууль зүйн туслалцаа үзүүлэх нь хүний нэр төр, алдар хүнд, шударга ёс, тэгш байдал гэсэн 3 үндсэн үнэт зүйлийн баталгааг хангах явдал юм гэж судлаачид үздэг.¹ Иймд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх нь төрийн бодлогын нэн тэргүүний асуудлуудын нэг байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударгаар шүүлгэх зэрэг эрхүүдийг хуульчилсан байдаг.² Мөн 55 дугаар зүйлд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй гээд уг эрхээ эдлэхэд нь хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг тусгажээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэжээ.³

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 14 дүгээр зүйлд “хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх, шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхтэйг”⁴ заасан байдаг.

Түүнчлэн НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба Эрүүгийн шүүх таслах ажиллагааны хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 21 дүгээр чуулганаар “Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим ба удирдамж”-ийг баталж, гэмт хэргийн сэжигтэн яллагдагч, хохирогч, гэрч зэрэг этгээдэд ялгаварлан гадуурхалгүй хууль зүйн туслалцааг тэгш хүртээмжтэйгээр хүргэх ёстойг улс орнуудад сануулсан байдаг.

Аливаа улсад үр нөлөөтэй, ирээдүйтэй хууль зүйн туслалцааны тогтолцоог бий болгох, бэхжүүлэх, хөгжүүлэх нь ихээхэн чухлыг НҮБ онцолж, ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ЗӨВЛӨЛ-өөс 2007 оны 7 сард “Эрүүгийн хэрэг шүүн таслах ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх олон улсын хамтын ажиллагаа-ялангуяа Африкт” гэсэн тогтоол гаргасан байдаг.

¹ Елена Бурмицкая “Эрүүгийн хэрэгт хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх дэлхийн загварууд”, 2009 он.

² Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг.

³ <http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/>

⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт <http://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

Монгол Улсад 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль хэрэгжиж бие даасан хууль бүхий эрх зүйн орчин бүрдсэн билээ. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ” гээд энэхүү зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөн 2020 он хүртэл хэрэгжүүлнэ гэжээ.⁵

Хэдийгээр Монгол Улс хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг анхааран тус нийгмийн харилцааг зохицуулсан эрх зүйн суурь буюу ерөнхий орчин бүрдүүлэх ажлуудыг хийсээр байгаа гэж үзэж болохоор боловч энэ хүрээнд цаашид улам боловсронгуй болгох олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх олон асуудлууд байсаар байна.

Судалгааны зорилго: Тус судалгааны зорилго нь үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах хэрэгцээт нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлох явдал боловч зөвхөн энэ асуудлаар явцууралгүй Монгол Улсад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог сайжруулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох буюу иргэд хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлж хамгаалахад хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх боломжийг эрэлхийлсэн болно. Ингэхдээ аливаа улс орны эрх зүйн үндсэн эх сурвалж болох олон улсын хүний эрхийн баримт бичгийг мөрдлөгө болгон үндэсний хууль тогтоомжийг энэхүү олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх үүднээс судалгааг гүйцэтгэсэн.

Судлах зүйл: Судалгааны эх сурвалжаа дараах 4 байдлаар ангилан авч үзлээ.

- Олон улсын хүний эрхийн баримт бичиг (ХЭТТ, ИБУТЭОУП, Хүүхдийн эрхийн конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх НҮБ-ийн зарчим ба удирдамж болон холбогдох бусад баримт бичиг);
- Монгол Улсын Үндсэн хууль, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль(2002), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль(2015), Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль зэрэг үндэсний 10 гаруй хуулиуд;
- Салбарын болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүрэм журам, хөтөлбөр;
- ХЗТТ-ийн болон холбогдох байгууллагын дүн мэдээ, статистик, 2014-2016 оны тайлан, судалгаа.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.10. <http://legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>

Судалгааны арга зүй: Энэхүү судалгааг судлаачийн биеэ даасан байдлаар буюу улс төрийн болон бусад нөлөөнөөс ангид, түүхчлэх, харьцуулах, анализ хийх аргуудаас гадна ажиглалтын болон ярилцлагын аргыг ашиглан гүйцэтгэв.

НЭГ. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ОНЦЛОГ

2013 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалд энэхүү хууль батлагдсанаар “Үндсэн хуулиар баталгаажсан хууль зүйн туслалцааг авах, төлбөрийн чадваргүйн улмаас эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлснээр шударга шүүхээр шүүлгэх эрх нь хангагдах ач холбогдолтой... Монгол Улсын иргэдийн Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн баталгаа дээшилнэ.” гэж үзсэн байна. Монгол Улсад тус хууль батлагдан хэрэгжиж 3 жил гаруйн нүүрийг үзэж байгаа нь манай улсад төлбөрийн чадваргүй иргэддээ хууль зүйн туслалцааг үзүүлж буй сайн жишиг тогтоосны илрэл болж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн баримт бичгүүд, бусад хуульд заасан “... өөрийгөө өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх”-ийг Хууль зүйн туслалцааны төв болон МХХ тус тусын хуульд заасны дагуу хэрэгжүүлж байна.

1.1. Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны талаарх Монгол Улсын эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударгаар шүүлгэх зэрэг эрхүүдийг мөн 55 дугаар зүйлд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй ... уг эрхээ эдлэхэд нь хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг заасан байдаг. Энэхүү Үндсэн хуульд заасан эрхийг эдлүүлэх эрх зүйн харилцааг тодорхой болгох үүднээс 2014 онд “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль” батлагдан бие даасан хуультай болж эрх зүйн орчин сайжирсан.

Тус хуулийн хүрээнд анх удаа “Улсын өмгөөлөгч” гэдэг статустай өмгөөлөгч нар бий болж төрийн зүгээс иргэдийг өмгөөлөх болсон ба тэдгээр нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн, шүүхэд төлөөлөх эрхтэй, Хууль зүйн туслалцааны төвөөс сонгон шалгаруулсан хуульч байна гэжээ. Улсын өмгөөлөгчдийг ажиллуулснаар төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч авах боломжгүй, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хамгаалж чадахгүй байгаа, эрх зөрчигдөх магадлалтай болон зөрчигдсэн иргэд хууль зүйн туслалцаа авах, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг нь төрөөс бүрдүүлж өгч байгаа хэрэг юм.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиас гадна Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, ЭХХШТХ, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай болон бусад хууль, холбогдох дүрэм журмаас бүрдэнэ.

Тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ЭБШХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1-ийн 6 дах хэсэгт “төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан” бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй гэж заасан байна. Мөн 2017 оны 7 дугаар 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байгаа хүн, өсвөр насны, монгол хэл, бичиг мэдэхгүй буюу гадаадын иргэн, бүх насаар нь хорих ял оногдуулж болох, хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад нь, төлбөрийн чадваргүй хүн өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол ЭХХША-г өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй гэсэн нь үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан явдал юм.

Түүнчлэн ХЗТТ-ийн улсын өмгөөлөгчдөөс гадна МХХ Хуулийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар “мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, хуульчийн нийэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах” үүргийг хүлээж төлбөрийн чадваргүй эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлдэг эрх зүйн зохицуулалт байдаг⁶ ба өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна гэсэн заалт байдаг ч одоог хүртэл хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байсаар байгаа хуулийн заалт юм.

1.2. Монгол Улсын хууль зүйн туслалцааны тогтолцоо, үүсэл хөгжил

Аливаа улсын эрх зүйн тогтолцоонд хууль зүйн туслалцаа ихэвчлэн албан ёсны буюу хуулиар үүрэг хүлээсэн этгээд ба сайн дурын гишүүд гэсэн 2 хэлбэрээр хэрэгжүүлдэгийн нэгэн адилаар Монгол Улсын төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоо нь албан ба албан бус гэсэн хэсгээс бүрэлдэн тогтож байна. Албан тогтолцоонд Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын холбоо багтаж байгаа бол албан бус тогтолцоонд Хууль зүйн клиник төвүүд, Төрийн бус байгууллагуудын хууль зүйн туслалцааны үйл ажиллагаа, паралегал нарыг хамруулж болох юм.⁷

Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулан заасан хууль зүйн туслалцаа авах иргэдийн эрхийг хэрэгжүүлжүүлэх үүднээс 2004-2006 онд “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагын санхүүжилтээр Хэнтий аймаг болон Сонгинохайрхан дүүрэгт “Эрх зүйн туслалцааны төв”-ийг туршилтын журмаар ажиллуулсан нь манай улсын хууль зүйн туслалцааны тогтолцоог бий болгох үндэс суурь болжээ. Үүний үр дүнд төлбөрийн чадваргүй иргэдийн эрхийг хамгаалах тусгай бүтэц бүхий нэгж байх нь зүйтэй төдийгүй хууль зүйн туслалцааны хүртээмжийг дээшлүүлэх үр нөлөөтэй гэсэн дүгнэлтэд хүрч, “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний

⁶ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 45.1.11

⁷ Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн “Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн гарын авлага. УБ., 2013. 47 дахь тал

хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор⁸ баталжээ. Тус хөтөлбөр батлагдах болсон үндэслэлийг “Монгол Улсад эрүүгийн хэрэгт холбогдсон, ял эдэлж буй хүмүүсийн 80 орчим хувь нь нэн ядуу, ядуу, боловсролын түвшин доогуур, ажилгүй өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй буюу амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай иргэд гэмт хэрэгт холбогдож байгаатай холбон тайлбарлаж, энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго бол “иргэдийн санхүүгийн байдлаас үл хамааран хууль зүйн туслалцааг тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлэх үндэсний тогтолцоог бий болгох явдал” гэж тодорхойлсон юм.⁹ Цаашилбал, хууль зүйн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 2008 оноос Хууль зүй, дотоод хэргийн яам, Нээлттэй нийгэм форум, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төсөл, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран эрх зүйн туслалцааны төвүүдийг байгуулж ажиллаж байсан.

Хууль зүйн туслалцааны төв байгуулагдахаас өмнө буюу Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх үүрэг хүлээлгэсэн байсан өмгөөллийн хөлс, ялангуяа хөнгөн, хүндэвтэр хэрэгт олгох хөлсний хэмжээ харьцангуй бага байдгаас хэрэг, маргаанд өмгөөлөгчөөр оролцох сонирхол байдаггүй, тэдгээр нь үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхээс байнга татгалзах асуудал гарч энэ төрлийн үйлчилгээг явуулахад бэрхшээлтэй байсан байна.¹⁰

Ийнхүү 2014 он хүртэл буюу Хууль зүйн туслалцааны төв хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахаас өмнө Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчид сайн дурын, үнэ төлбөргүй өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байсан нь албан тогтолцооны үндсэн загвар байсан бөгөөд 2014 оныг хүртэл эрүү, иргэн, захиргааны 3 төрлөөр жилд дундажаар 370 орчим буюу 2006-2014 оныг хүртэл нийт 2955 хүсэлтийг хүлээн авч байжээ.¹¹ Харин Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар 2014 оноос одоог хүртэл төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг Монголын Хуульчдын Холбоо хэрэгжүүлж 3 жилд нийт 409 хүсэлтийг хүлээн авч 320 өмгөөлөгчийг томилсон байна.¹² Дэлгэрүүлж үзвэл нийт 3 жилд ирүүлсэн хүсэлтийн 45 хувь нь эрүүгийн хэрэгт, 44,4 хувь нь иргэний хэрэгт харин 10,5 хувь нь захиргааны хэрэгт туслалцаа авахаар хүсэлт ирүүлсэн байна.¹³

⁸ “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор батлан, улсын хэмжээнд нийт 37 Эрх зүйн туслалцааны төвийг бүх аймаг, нийслэлийн дүүрэг, зарим алслагдсан сумдад байгуулж, нийт 37 гэрээт өмгөөлөгч үйл ажиллагаа явуулж байсан төдийгүй тухайлбал 2008 онд Эрх зүйн туслалцааны төвүүд нийт 470 эрүүгийн хэргийн холбогдогчид үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж, 1700 орчим иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч, 1500 иргэнийг эрх зүйн албан бус сургалтад хамруулж байжээ.

⁹ Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч-гарын авлага, УБ, 2014 он.

¹⁰ Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгаа, 2016 он

¹¹ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны 2017 оны № 17/87 тоот албан бичгийн хавсралтаас авч ашиглав.

¹² Монголын Хуульчдын Холбооны 2017 оны №2/75 тоот албан бичгийн хавсралтаас иш татав.

¹³ Мөн тэнд.

Хууль зүйн туслалцааны төв нь “хууль зүйн зөвлөгөө өгөх”, “өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн 2 төрлөөр хуульд заасны дагуу хууль зүйн үйлчилгээг Монгол Улсад үзүүлж байна. Хуульд зааснаар¹⁴ зөвхөн гэмт хэрэгт буруутгагдан шалгагдаж буй эрүүгийн хэргийн холбогдогч сэжигтэн, яллагдагчид хууль зүйн үйлчилгээ үзүүлж, өмгөөллийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй улсын өмгөөлөгч нар иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгсөөр байгаа нь улсын өмгөөлөгч нартай хийсэн ярилцлагын судалгаанаас харагдаж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц, зохион байгуулал:

Тус төв нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага бөгөөд бүтэц нь захирал, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, ажлын алба болон салбар нэгжтэй байна. Захирал нь Төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, төв болон салбарын ажлын чиглэл, төлөвлөгөөг батлах, тайланг сонсох, тэдгээрийн үйл ажиллагааны жигд хэвийн байдлыг хангахад чиглэсэн чиглэл шийдвэр гаргадаг. Хуульд зааснаар тус төвийн бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоохоор заасны дагуу тус байгууллагыг Ажлын алба, Салбар гэсэн 2 бүтэцтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд байгуулсан ба 2016 оны 12 сарын 26-ны А133/437 тоот тушаалаар үүнээс ажлын алба 13, улсын өмгөөлөгч 52, улсын өмгөөлөгчийн туслах 7, нийт 72 албан хаагчидтай нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг болон хүн ам ихтэй 2 сумыг хамруулан 31 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

1.3. Монгол Улсад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсад хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар ХЗТТ болон МХХ гэсэн 2 бие даасан байгууллага хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, 2013 онд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг Хууль зүйн туслалцааны төвд, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг Монголын Хуульчдын холбоонд тус тус шилжүүлсэн байна.

ХЗТТ-ийн төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлж буй хууль зүйн туслалцаа


Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдан хэрэгжсэнээс хойш 3 жил болж байна. 2014 онд улсын хэмжээнд 6375 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 1895 хэргийн 2102 холбогдогчид буюу 31,1 хувьд, 2015 онд 6576 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэнээс 1787 хэргийн 3145 холбогдогчид буюу 50.9 хувьд, 2016 онд

¹⁴ Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна” гэжээ.

5762¹⁵ хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 2339¹⁶ хэргийн 2572 холбогдогчид буюу 40.5% хувьд улсын өмгөөлөгч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна.

МХХ-оос ирүүлсэн 2015 оны статистик мэдээнд улсын хэмжээнд шүүх төлөөлөх эрхтэй 1931 өмгөөлөгч бүртгэгдсэн талаар дурдсан байна. Үүнээс Хууль зүйн туслалцааны төвд 47 улсын өмгөөлөгч ажиллаж байгаа нь нийт өмгөөлөгчдийн 2,4%-ийг эзэлж байна. Харин 2016 оны байдлаар улсын өмгөөлөгч нь нийт өмгөөлөгчдийн 2.5%¹⁷-ийг эзэлж байгаа ба 2014-2016 оны дунджаар нийт шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэргийн 40.8%-д улсын өмгөөлөгч оролцсон байна.

Графикаар харуулбал: (2015 оны байдлаар)



Төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлсэн тоог хүснэгтлэн үзүүлбэл: /зөвлөгөө өгсөн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон/¹⁸

Д/д	Хууль зүйн туслалцааны төрөл	2014 он	2015 он	2016 он
1	Өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн тоо	1891	2888	2482
2	Хууль зүйн зөвлөгөө өгсөн тоо	7351	8363	6631

¹⁵ Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. УБ.,2016 он. 11 дэх тал.

¹⁶ Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны 2014, 2015, 2016 оны тайлан.

¹⁷ Монголын хуульчдын холбооны цахим хуудас. Хуульчдын тоо, нэгдсэн статистик. <https://www.mglbar.mn/?action=content&view=category&layout=detail&id=23>. 2017.5.6-ны өдөр зочилсон.

¹⁸ Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны 2014, 2015, 2016 оны тайлан.

Улсын өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авсан гэмт хэргийг төрлөөр нь авч үзэхэд бусдын өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 55 орчим хувийг эзэлж байгаа нь харагдаж байна. 2014-2016 онд үйлчилгээ үзүүлсэн хэргийн төрлөөр ангилан үзэхэд

- Бусдын эд хөрөнгийг хулгайлах 2019 буюу 39.4%
- Бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл санаатай учруулах 1037 буюу 20.3%
- Танхайрах 432 буюу 8.4%
- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 318 буюу 6.1%
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 265 буюу 5.03%
- Бусад гэмт хэрэг 916 буюу 18%-ийг эзэлж байна.¹⁹



Гэмт хэргийн төрөл



Үзүүлэлтээс харахад үнэ төлбөргүй өмгөөлөлийн үйлчилгээ авсан иргэдийн дийлэнх нь буюу 53% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байгаа нь тэдгээр иргэд эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтмол орлогогүй, амьдралын түвшин доогуур буюу эдийн засгийн нөхцөл байдал муу байгаатай шууд хамааралтай гэж үзэж болох байна. Нөгөө талаас боловсрол, хуулийн мэдлэг багатайгаас өөрийн үйлдлийн учир холбогдол, хариуцлагыг ухамсарлах чадвар сул байгааг харуулж байна.²⁰

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Мөн тэнд.

Пробоно үйл ажиллагаа²¹ буюу МХХ-ны хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа

Монгол Улсад хуульд зааснаар төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага буюу ХЗТТ-өөс гадна иргэдэд зориулж үнэ төлбөргүй хууль зүйн мэргэжлийн туслалцааг МХХ болон зарим төрийн бус байгууллага сайн дурын үндсэн дээр үзүүлж байна.²²

Дээр дурдсанаар МХХ 2014 оноос одоог хүртэл төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж 3 жилд нийт 460 хүсэлтийг хүлээн авч 320 өмгөөлөгчийг томилсон ба²³ хүсэлтийн 45 хувь нь эрүүгийн хэрэгт, 44.4 хувь нь иргэний хэрэгт харин 10.5 хувь нь захиргааны хэрэгт туслалцаа авахаар хүсэлт ирүүлсэн байна.²⁴ Мөн 2017 оны эхний хагас жилийн байдлаар 96 хэрэгт хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлээд байна.²⁵

2017 оны I улиралд өмгөөлөгч томилуулахаар хандсан иргэдийг өмнөх онуудтай харьцуулан үзвэл өсөх хандлагатай байгаа нь хууль зүйн туслалцаа иргэдэд хэрэгцээтэй байгааг харуулж байгаа жишээ юм.



1.3.1. Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нэн хэрэгцээт зорилтот бүлгийг тодорхойлох нь

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нь тухайн этгээдийн орлого, эрүүл мэнд, аюулгүй байдал, байршил болон туслалцаа хүсч буй асуудал нь эрүү, иргэнийх байх зэрэг олон асуудлаас хамаардаг. Дэлхийн улс орнуудад хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг хэнд үзүүлэх вэ гэсэн асуудалд 2 үндсэн байр сууринаас ханддаг байна. Нэгдүгээрт, үнэ төлбөргүй туслалцаа хүртэх

²¹ Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх энэхүү хэлбэр нь латин гаралтай Pro bono publico - Нийтийн тусын тулд гэсэн үгнээс гаралтай бөгөөд олон улсад Pro Bono гэж нэршсэн.

²² "Иргэний хамгаалалт" хууль зүйн туслалцаа үзүүлэх төв хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна. МХХ-ны ажилтантай хийсэн ярилцлагаас.

²³ Монголын Хуульчдын Холбооны 2017 оны №2/75 тоот албан бичгийн хавсралтаас иш татав.

²⁴ Мөн тэнд.

²⁵ МХХ-ны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэгч хорооны ажилтантай хийсэн ярилцлагаас.

гавьяатай байх, хоёрдугаарт үнэ төлбөртэй хүртэх боломжгүй буюу хөрөнгө, мөнгөгүй байх гэсэн 2 үзүүлэлтийг баримталж хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлдэг байна. Тухайлбал, Англид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа хүсэгч нь дараах шалгуур бүхий тестийг бөглөдөг байна. 1. Эрх чөлөөгөө алдах эрсдэлд байгаа, 2. Тэнсэнтэй ялтан, 3. Амьжиргааны эх үүсвэрээ алдах эрсдэлд орсон, 4. Нэр хүндэд нь ноцтой хор хохирол учирч болохуйц, 5. Хэрэг нь маш ээдрээ түвэгтэй байх. Харин Австралид А, В гэсэн 2 төрлийн тест бөглүүлэх ба хууль зүйн туслалцаа авснаар ямар давуу тал болон сул талыг авчрах тухай асуусан байдаг. Канад улсад хөрөнгө, орлогоо тодорхойлох тестийг авдаг бол Англи улсад тест бөглөж буй этгээд зөвхөн цалин орлогоо мэдүүлдэг онцлогтой байна.²⁶ Харин БНСУ-д нилээд олон тарлийн этгээдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг онцлогтой.

1. Дотоодын иргэн, гадаадын иргэдийн сарын дундаж орлого стандарт дундаж орлогоос 12 хувиас доош тохиолдолд,
2. Загасны аж ахуйн хуульд заасан субъектууд болох аж ахуй эрхлэгч, загасчин, усан болон авто тээврийн ажилчид,
3. Нийгмийн халамж авагч болон өндөр настны тэтгэвэр авагч,
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бага насны бүтэн өнчин хүүхэд, хоригдсон хүүхэд,
5. Үндэсний гавьят, үндэсний болон тусгаар тогтнолын эх оронч, ардчиллын гавьяат иргэн,
6. Ахмад дайчин, тусгай даалгавартай байсан ахмад дайчин болон цэргийн дунд болон урт хугацаагаар үйлчилгээнд гарсан цэргийн тэтгэвэр авах эрхгүй цэргийн ахмад,
7. Далайчны хуулийн дагуу далайчинд гэнэтийн ослын болон гамшигт үзэгдэлд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор төлөгдөөгүй бол,
8. Дотоодын болон гадаадын бэлгийн хүчирхийллийн хохирогч,
9. Өөр өөр үндэстний гэрлэлтийн талаар,
10. Ганц бие эцэг эсвэл эх,
11. Гэр бүлийн бүртгэлд ороогүй иргэн,
12. Эрүүгийн хохирогч,
13. Хойд Солонгосоос оргосон дүрвэгч этгээд,
14. Худалдааны болон жижиг аж үйлдвэрлэлийн сарын дундаж орлого нь стандарт орлогоос 125 хувиас бага бол.²⁷

Монгол Улсын тухайд одоогийн байдлаар “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д заасан шалгуурыг хангасан “үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн, нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүн, Хүүхэд хамгааллын

²⁶ Елена Бурмицкая “Эрүүгийн хэрэгт хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх дэлхийн загварууд”, 2009 он.

²⁷ Хууль зүйн туслалцааны төвийн харьцуулсан судалгаанаас авч ашиглав.

тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн 3 төрлийн яллагдагчид хууль зүйн туслалцааг үзүүлж байна. Энэ нь ихээхэн явцуу хүрээнд томъёологдсон гэж судлаачид, хуулийн байгууллагын ажилтнууд, иргэд үзэж байгаа юм.

Иймд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг үзүүлэх хэрэгцээт бүлгийг тодорхойлох зорилгоор 1. иргэд (Хөдөө орон нутгийн болон Улаанбаатар хотын иргэд хамрагдсан) 2. Улсын өмгөөлөгч (Улаанбаатар хотын 8 дүүргийн мөн хөдөө орон нутгийн улсын өмгөөлөгч нар хамрагдсан) 3. Хуулийн байгууллагын ажилтан (Улаанбаатар хотын 8 дүүргийн шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтан хамрагдсан) гэсэн 3 зорилтот бүлгийг хамруулсан судалгааг²⁸ явуулсан болно.

Иргэдээс авсан судалгааны дүн:

Судалгаанд оролцогчдын 28.2% нь иргэний хэргийн оролцогч, 25.6% нь эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, 9.4% нь захиргааны хэргийн оролцогч, 9.4% нь эрүүгийн хэргийн хохирогч, 6.4% нь насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагч, 12.3% нь бусад этгээд байлаа.

Хууль зүйн туслалцаа авч байсан иргэдийн 75.2% нь хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авсан байна. Судалгаанд оролцогчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авахад ямар хүндрэл, бэрхшээл тулгарч байна вэ гэсэн асуултанд 33.3% нь өмгөөлөгч хүрэлцээгүй, 42.3% бусад, 7.2% нь хангалттай зөвлөгөө, туслалцаа үзүүлээгүй, 2.5% нь хүнд сурталтай, хүндрэл чирэгдэл учруулдаг, 1.7% нь эрх зүйн байдлыг дордуулсан гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдоос эрх зүйн харилцааны хэрэг маргаанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа тэргүүнд шаардлагатай этгээд аль нь вэ гэсэн асуултанд 50% нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэний хэргийн холбогдогчид, 49.5% нь эрүүгийн хэргийн сэжигтэн яллагдагч, 41.8% нь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн хохирогч, 39.3% нь эрүүгийн хэргийн насанд хүрээгүй хохирогч, 36.3% нь эрүүгийн хэргийн хохирогч, 23.9% нь хөдөлмөр газрын хэрэг маргааны төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн холбогдогчид, 20.9% нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн захиргааны хэргийн холбогдогчид, 3.8% нь бусад гэж хариулсан нь манай улсын эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байгааг харуулж байна. Иргэдэд иргэний хэрэг маргааны чиглэлээр ялангуяа гэр бүлийн, хөдөлмөрийн маргаан дээр хууль зүйн туслалцаа ихээхэн хэрэгцээтэй байгаа дээрх судалгаанаас гадна иргэдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын явцад ажиглагдсан.

²⁸ Тус санал асуулгын судалгааг ХЗТТ-ийн тусламжтайгаар 2017 оны 4 сард шинэчлэн авсан.



Судалгаанд оролцогчдоос эрх зүйн харилцааны хэрэг маргаанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа тэргүүнд шаардлагатай этгээд аль нь вэ



Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэний хэргийн холбогдогчид -50%



Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн захиргааны хэргийн холбогдогчид -20.9%



Хөдөлмөр газрын хэрэг маргааны төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн холбогдогчид -23.9%



Эрүүгийн хэргийн насанд хүрээгүй хохирогч -39.3%



Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн хохирогч -41.8%



Эрүүгийн хэргийн сэжигтэн яллагдагч -49.5%



Эрүүгийн хэргийн хохирогч -36.3%



Бусад -3.8%

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай нийгмийн зорилтот бүлэг аль нь вэ гэсэн асуултанд оролцогчдын 56.8% нь өрх толгойлсон олон хүүхэдтэй эх болон эцэг, 55.9% нь өрхийн амжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн-иргэн, 54.2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 48.2% нь олон хүүхэдтэй эмзэг бүлгийн эцэг, эх, 43.1% нь 18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсэн 18-24 насны иргэн, 40.5% нь гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрхийн гишүүн-иргэн, 36.7% нь хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн орон гэргүй, ажилгүй иргэн, 32.4% нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан, 21.3% нь байнгын асаргаа шаардлагатай иргэн, 9.4% нь МУ-ын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтой ахмад настан, 9.3% нь согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн, 1.7% нь бусад гэсэн хариулт өгчээ.

Судалгаанд оролцогчдоос таны бодлоор үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны чанар, хүртээмж ямар байна вэ гэж асуусан асуултанд 64.1% нь сайн, 31.1% нь дунд, 4.2% нь муу гэсэн нь Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа 3 жил гаруйн хугацаанд хэрэгжиж байгаа ч дээрх үзүүлэлтээс үзэхэд

иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчид өмгөөллийн үйлчилгээний талаар хангалттай үнэлгээтэй байгааг харуулж байна.

Улсын өмгөөлөгчдөөс авсан судалгааны дүн:

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчдийн хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ нэн шаардлагатай байгаа нийгмийн бүлэг гишүүд, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс бусад иргэдийн хандалтын талаар давхардсан тоогоор судалгааг хийв.

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай төлбөрийн чадваргүй бүлгийн талаар 97.7% нь “сэжигтэн, яллагдагч”, 65.9% нь “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” 63.6% нь “насанд хүрээгүй этгээд”, 59% нь “төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэний хэргийн холбогдогч”, 54.5% нь “гэр бүлийн хэрэг маргааны төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн оролцогч”, 52.2% нь “хохирогч”, 36.3% нь “хөдөлмөр, газрын хэрэг маргааны төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн оролцогч”, 25% нь “төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн захиргааны хэргийн холбогдогч” гэж үзжээ.



Дээрх судалгааны дүнгээс үзэхэд эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байгаа одоогийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны тогтолцооны ач холбогдлыг харуулж байгаа төдийгүй насанд

хүрээгүй этгээд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, төлбөрийн чадваргүй эмзэг бүлгийн иргэний хэргийн оролцогч, гэр бүлийн хэрэг маргааны эмзэг бүлгийн төлбөрийн чадваргүй оролцогч нар хууль зүйн туслалцаа нэн хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай нийгмийн зорилтот бүлэг аль нь вэ гэсэн асуултанд 88.6% нь “өрхийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн-иргэн”, 77.2% нь “хөгжлийн бэрхшээлтэй иргэн”, 77.2% нь “гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрхийн гишүүн-иргэн”, 75% нь “олон хүүхэдтэй эмзэг бүлгийн эцэг болон эх”, 70.4% нь “өрх толгойлсон олон хүүхэдтэй эх болон эцэг”, 65.9% нь “18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсөн 18-24 насны иргэн”, 61.3% нь “хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн орон гэргүй, ажилгүй иргэн”, 29.5% нь “ өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан”, 27.2% нь “байнгын асаргаа шаардлагатай иргэн”, 13.6% нь “согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн”, 4.54% нь “Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настан” гэж хариулжээ.

Хууль зүйн туслалцааны төвөөс төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн эрүүгийн хэргийн хохирогч, иргэн, захиргааны хэргийн холбогдогч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах талаар тухайн жилд ирдэг хүсэлтийн тоо хэд вэ гэсэн асуултанд “Эрүүгийн хэргийн хохирогчийн тоо 343, төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэний хэргийн хохирогч 461, төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн захиргааны хэргийн хохирогч 158 гэж хариулсан нь эрүүгийн хэргийн хохирогч болон иргэний хэрэг маргаанд оролцогчдод хууль зүйн туслалцаа ихээхэн хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэгт хамаарахгүй чиглэлээр хууль зүйн туслалцаа авахыг хүссэн иргэдийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэдэг талаар 84% нь “холбогдох байгууллагад буюу ХЗТТ-д хандах талаар зөвлөгөө өгч, чиглүүлдэг”, 22.7% нь “Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо руу хүсэлтийг шилжүүлдэг”, 6.8% нь “хуульд заасан эрх үүргийн дагуу улсын өмгөөлөгчид хамааралгүй тул шийдвэрлэдэггүй”, 9% нь “Монголын Өмгөөлөгчдийн холбоо болон хүний эрхийг хамгаалдаг олон нийтийн байгууллагууд руу хүсэлтийг шилжүүлдэг” гэсэн байна.

Улсын өмгөөлөгчид хандаж анхан шатны хууль зүйн зөвлөгөө авч буй иргэдийн 90.9% нь “эрүүгийн хэрэг”, 75% нь “гэр бүлийн маргаан”, 70.4% нь “гэр бүлийн хүчирхийллийн” 63.6% нь “иргэний хэрэг”, 52.2% нь “хөдөлмөрийн маргаан”, 50% нь “захиргааны хэрэг”, 40% нь “газрын маргаан”, гэсэн асуудлаар ханддаг гэж хариулснаас дүгнэн үзвэл хууль зүйн туслалцаа эрүүгийн хэргийн хэргийн сэжигтэн яллагдагч, хохирогчид, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар түүнчлэн иргэний хэрэгт тухайлбал, гэр бүлийн, хөдөлмөрийн хэрэг маргаанд ихээхэн хэрэгцээт байна.

Хуулийн байгууллагуудын ажилтнаас авсан судалгааны дүн:

Төлбөрийн чадваргүй буюу хууль зүйн туслалцаа авах боломжгүй нөхцөл байдалд байгаа нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлох мөн хууль зүйн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг тодруулах үүднээс шүүх, прокурор, цагдаа, бусад хуулийн байгууллагын ажилтны дунд санал асуулгыг зохион байгууллаа.

Судалгаанд оролцсон шүүх, прокурор, цагдаа, бусад байгууллагын албан хаагчдаас эрх зүйн харилцааны хэрэг маргаанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай бүлгийн талаар санал бодлыг асуухад 79% нь “Эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч”, 62.5% нь “Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн оролцогч”, 50.8% нь “Эрүүгийн хэргийн насанд хүрээгүй оролцогч”, 50% нь “Эрүүгийн хэргийн оролцогч”, 44.7% нь “Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэний хэргийн оролцогч”, 23.9% нь “Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн захиргааны хэргийн оролцогч”, 22.9% нь “Хөдөлмөр, газрын хэрэг маргааны төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн оролцогч”, 15.6% нь “Гэр бүлийн хэрэг маргааны оролцогч” гэж үзжээ.

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай нийгмийн зорилтот бүлгийн талаар 68.7% нь “Өрхийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн-иргэн”, 63.5% нь “Олон хүүхэдтэй эмзэг бүлгийн эцэг болон эх”, 62.5% нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн”, 53% нь “Өрх толгойлсон олон хүүхэдтэй эх болон эцэг”, 48% нь “Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрхийн гишүүн-иргэн”, 44.7% нь “18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсэн 18-24 насны иргэн”, 45.8% нь “Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн орон гэргүй, ажилгүй иргэн”, 32.2% нь “Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан”, 20.8% нь “Байнгын асаргаа шаардлагатай иргэн”, 16% нь “Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн”, 7.2% нь “МУ-ын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настан”, 4.1% нь “Бусад” гэсэн хариулт өгчээ. Үүнийг хүснэгтлэн үзүүлбэл,

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай нийгмийн зорилтот бүлгийн талаар



Хөгжлийн бэрхшээлтэй иргэн -62.5%



Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан -32%



Өрх толгойлсон олон хүүхэдтэй эх болон эцэг -53%



Олон хүүхэдтэй эмзэг бүлгийн эцэг болон эх - 63.5%



МУ-ын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настан -7.2%



Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрхийн гишүүн иргэн -48%



Байнгын асаргаа шаардлагатай иргэн - 20.8%



Хорих ангвас суулагдсан өөрийн гэсэн орон гэргүй, ажилгүй иргэн -45.8%



Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн -16%



18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсөн 18-24 насны иргэн -44.7%



Өрхийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн иргэн -68.7%



Бусад -4.10%

Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн эрүүгийн хэргийн оролцогч, иргэн, захиргааны хэргийн холбогдогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломжоор хэр зэрэг хангагдаж байгаа талаар 20.8% нь “Хангалттай”, 42.7% нь “Дунд зэрэг”, 36.5% нь “Хангалтгүй” гэж үзсэн байна.

Иргэдээс хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ авах боломжоор хангаж өгөх талаар хүсэлт гардаг уу? Тийм бол Та хэрхэн шийдвэрлэдэг вэ? гэхэд 67.7% нь “Хууль зүйн туслалцааны төвд хүсэлтийг шилжүүлдэг”, 16% нь “Хуульд заасан эрх үүргийн дагуу манай байгууллагад хамааралгүй тул шийдвэрлэдэггүй”, 14.5% нь “Монголын Өмгөөлөгчдийн холбоо болон хүний эрхийг хамгаалдаг олон нийтийн байгууллагууд руу хүсэлтийг шилжүүлдэг”, 6.2% нь “Монголын хуульчдын холбоонд хүсэлтийг шилжүүлдэг” гэж хариулжээ.

Хууль зүйн туслалцааг хэнд үзүүлэх шаардлагатай талаар хуулийн байгууллагын ажилтнуудын саналыг нэгтгэн дүгнэвэл,

- Өрхийн орлого хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд дөнгөж хүрээд илүү гарсан буюу 300.000-500.000 төгрөгийн орлоготой иргэдийг хамруулах.
- Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа шаардлагатай иргэдийг цагдаа, прокурор, шүүхээс тодорхойлсон албан тоот, хорооны

засаг дарга, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн тодорхойлолтоор тогтоож болно.

- Нэн ядуу хохирогч ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч, өндөр настан, тахир дутуу хүмүүс, төлбөрийн чадваргүй өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг, эхчүүд, тэнэмэл хүмүүс болон эрүүгийн хэргийн насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг нийгмийн зорилтот бүлгийн нэн тэргүүнд тавих.
- Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхэд өмгөөлөгчдийн тоо цөөн учир зорилтод бүлгийнхэнд хүртээмжтэй хүрэхэд учир дутагдалтай байна.
- Хуулиа мэддэггүйн улмаас хохирох тохиолдол маш их байдаг тул хууль зүйн сургалт иргэдэд явуулах хэрэгтэй.

1.3.2. Өнөөгийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд тулгамдаж буй асуудал

Хууль зүйн туслалцааны төвөөс иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад дараах хүндрэл бэрхшээлтэй асуудлууд тулгарсаар байгаа нь дээрх санал асуулгын дүн, улсын өмгөөлөгч, иргэд, холбогдох хуулийн байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагын болон бичиг баримтын судалгаа хийх явцад ажиглагдлаа.

1. Ихэвчлэн хаана хандахаа мэдэхгүй иргэд улсын өмгөөлөгчид ханддаг. Өөрсдөө ямар ч орлогогүй төлбөрийн чадваргүй, нэн ядуу өрх гэх боловч өрхийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх гэсэн судалгаанд хамрагдаагүй, эсвэл хөдөө орон нутгийн хаягтай байдаг. Өөрөөр хэлбэл, тодорхой оршин суух хаяггүй тул өрхийн мэдээлэлд бүртгэгдээгүй орон гэргүй иргэд их байдаг ба эрх нь зөрчигдсэн ч хууль зүйн туслалцаа авахгүй байх нь түгээмэл байна.

2. Эдийн засгийн нөхцөл, иргэдийн амьжиргааны түвшин, ажилгүйдэл зэрэг хүчин зүйлүүдтэй холбоотойгоор орлогогүй, төлбөрийн чадваргүй болсон, хувийн өмгөөлөгчийн хөлс төлөх боломжгүй тул өмгөөллийн үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангаж өгөхийг хүссэн иргэдийн өргөдөл, хүсэлт ихээр ирж байна. Баг, хорооны Засаг дарга хүссэн иргэд бүрт төлбөрийн чадваргүй болох тухай тодорхойлолтыг хариуцлагагүйгээр хийж өгч байгаа, хуулийн байгууллагууд хэрэгт холбогдсон иргэн өмгөөлөгчгүйн улмаас байцаан шийтгэх ажиллагаа явуулж чадахгүйд хүрэх тохиолдол бүрт улсын өмгөөлөгч томилуулах хүсэлт ирүүлж байгаа зэргээс үүдэн улсын өмгөөлөгчдийн ачаалал их байна. Иймд “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүний талаарх цахим мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчдад нээлттэй байдлаар харах боломжийг бүрдүүлэх, хуурамч тодорхойлолт гаргасан албан тушаалтан, иргэнд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заах.

3. Улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал тодорхойгүй, эдийн засаг, нийгмийн баталгаа хангалтгүй, улсын өмгөөлөгчдийн орон тоо цөөрч, мэргэшсэн чадварлаг өмгөөлөгч улсын өмгөөлөгчөөр ажиллах нөхцөл бүрдэхгүй байна. Түүнчлэн улсын өмгөөлөгчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, үйлчилгээний чанарыг сайжруулахад тэдний цалин, урамшууллыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж бусад хуульчдын цалингийн жишигт ойртуулах. *“Улсын өмгөөлөгчийн цалин бол маш бага гэж боддог. Тэтгэврийн насны хүнд шинээр орон байр авах хэрэгцээ бага болохоор энэ цалингаараа өдөр хоногоо өнгөрүүлээд байж болдог. Харин ирээдүйтэй залуу хүмүүсийн хувьд хаанаа ч хүрэхгүй. Хувийн өмгөөлөгчийн нэг хэрэг дээр авдаг цалингийн талд ч хүрэхгүй мөнгөөр бүтэн сар ажилладаг. Ийм бага цалинтай учир чадвартай, сайн өмгөөлөгчдийн тогтвортой ажиллах боломжийг хаадаг. Ялангуяа хөдөө орон нутагт улсын өмгөөлөгчөөр ажиллах сонирхолтой хуульч байдаггүй.”* гэж нэгэн улсын өмгөөлөгч ганцаарчилсан ярилцлагын судалгаанд өгүүлжээ.²⁹

4. Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх буюу төлбөрийн чадваргүй гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн оролцогч нарыг хамруулах. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна” гэж заасан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д “төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол заавал өмгөөлөгчтэй оролцуулах”-аар ЭХХШТХ-ийн 5.3-т ЭХХША-г өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй гэж зохицуулсан нь гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд үнэ төлбөргүй өмгөөлөгч томилуулах эрхтэйг заасан.³⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, Арван зургадугаар зүйлийн 16.14 “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ...” эрхийг иргэн бүр эдлэхээр заасан. Түүнчлэн дээр дурдагдсан судалгаанаас үзэхэд зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг тодорхой харж болох юм. Гэтэл Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль нь зөвхөн төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон яллагдагчид хамааралтай байхаар зохицуулсан нь энэхүү хуулийн зохицуулалтын хүрээг хязгаарлаж, яллагдагчаас бусад төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд хүргэж байна.³¹

²⁹ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааны тайлан, ХЗҮХ, 2017 он.

³⁰ ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³¹ Мөн тэнд.

5. Хэргийн төрөл харгалзахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй иргэд, иргэний хэргийн хувьд гэр бүл, тэтгэмж гаргуулах маргааны зохигч нар улсын өмгөөлөгчөөс хууль зүйн зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага их байдаг, мөн захиргааны хэрэгт газрын маргаанд холбогдуулан хууль зүйн зөвлөгөө авч байна. “Хууль нь зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагч гэж гарсан боловч эрүүгийн хэргийн хохирогч, иргэн болон захиргааны хэрэгт зөвлөгөө туслалцаа авч байгаа иргэд их байна. Энэ нь эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна. Эрх зүйн туслалцааны төв байх үед эрүү, иргэн, захиргааны хэрэгт туслалцаа үзүүлж байсан. Гэхдээ эрүүгийн хэрэгт голлон анхаарч байсан. “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль” гарсны дараа зөвхөн эрүүгийн хэрэгт ажиллах болсон. Зөвлөгөө авч байгаа хүмүүс маш их байна. Гэтэл энэ эрэлт байхад нийлүүлэлт алга. Захиргааны хэрэгт голчлон газрын маргаан, иргэний хэрэгт үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, нийгмийн даатгал төлөөгүй, гэр бүл салалт, тэтгэвэр тэтгэмжийн асуудал байж болно. Иргэд манайхаар үйлчлүүлээд маш их сэтгэл хангалуун байдаг. Мөн нөгөө талаас улсын өмгөөлөгч нарыг яагаад зөвхөн эрүүгийн хэрэгт туслалцаа үзүүлж байгааг лавласан асуулт байнга ирдэг.”³² гэж ХЗТТ-ийн захиралтай хийсэн ярилцлагад дурджээ.

6. Эрүүгийн хэргийн хохирогч нарт хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх хэрэгцээ шаардлага маш их байна. Төв аймгийн прокурор С-тэй хийсэн ярилцлагын судалгаанд “Хууль зүйн туслалцааг төлбөргүй чадваргүй хохирогч нар руу хандуулмаар байна. Энэ субъектыг хуульчлан оруулах нь зүйтэй. Ялангуяа насанд хүрээгүй хохирогч нар тэр тусмаа бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт хохирсон хүүхдүүд их байдаг. Тэдэнд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үнэхээр хэрэгтэй.” гэжээ. Мөн “Эрүүгийн хохирогч нарыг хуульд хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээдээр нэмж оруулбал зүгээр байна. Гэхдээ хохирогч нарыг ангилах хэрэгтэй, ялангуяа бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарт туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Тэрнээс өмчийн эсрэг гэмт хэргийн хохирогч нарыг оруулах хэрэггүй.” гэж улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагын судалгаанд мөн л энэ асуудлыг хөндсөн байна.

7. Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалт Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд байхгүй. Гэсэн хэдий боловч ЭБШХ-д монгол хэл, бичиг мэдэхгүй хүнд өмгөөлөгч заавал оролцуулахаар хуульчилсан тул төлбөрийн чадваргүй гадаадын иргэд нилээд хандаж үйлчлүүлсэн байна. Иймд гадаадын иргэний төлбөрийн чадваргүй эсэхийг хэрхэн тогтоох асуудлыг тодорхой болгох. Монгол Улс эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай тусгайлан зохицуулсан олон талт “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх конвенц”, 2 талт “одоогийн байдлаар 20 оронтой эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ /иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, худалдааны, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай/, 4 оронтой гэмт этгээдийг шилжүүлэх өгөх тухай гэрээ, 2 улстай ялтан шилжүүлэх тухай”³³ гэрээ байгуулсан байдаг.

³² Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааны тайлан, ХЗҮХ, 2017 он.

³³ Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас.

http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа_харилцан_үзүүлэх_нь.html.

8. Олон нийтэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа, ХЗТТ болон улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэл сайн хүргэх. Тухайлбал, фокус бүлгийн ярилцлагын судалгаанд оролцсон 25 иргэний 60 хувь нь буюу 15 нь энэ талаар мэдээлэл муутай байлаа. Эрхэлсэн ажилгүй, сэтгэцийн өвчтэй, орлого багатай, бага, дунд боловсролгүй буюу бичиг үсэггүй, алслагдсан сум суурингийн хүмүүс зэрэгт хууль зүйн туслалцаа хэрэгтэй боловч төлбөрийн чадваргүй тул эрхээ хамгаалуулах аргаа мэддэггүй. Тэд улсын өмгөөлөгч гэж хүн байдгийг ч мэддэггүй байх нь элбэг.³⁴

ХОЁР. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БА ХҮНИЙ ЭРХ: ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ, СТАНДАРТ, ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

2.1. Олон улсын хүний эрхийн үндсэн эх сурвалж буюу үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нь

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг олон улсын гэрээ, конвенциудад олноор тусгаж, хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг тунхагласан байдаг. Тухайлбал, **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын** 11 дүгээр 1 дэх хэсэгт “гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэжээ.³⁵

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 14 дүгээр зүйлд “хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх, шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхтэйг”³⁶ заасан байдаг.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 37 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр хууль зүйн болон бусад туслалцааг даруй авах, түүнчлэн ... эрхтэй” гэсэн байдаг.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 6 дугаар зүйлд түүнчлэн **Цагаач ажилтан, түүний гэр бүлийн бүхий л эрхийг хамгаалах олон улсын конвенцийн** 18 дугаар зүйлийн 2 болон 4 дэх хэсэгт цагаач иргэд нь өөрсдийн сонгосон этгээдээр өмгөөлүүлэх, хэрвээ түүнд үзүүлэх хууль зүйн туслалцаа байхгүй тохиолдолд эрх бүхий этгээд томилох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаагаар хангах эрхтэйг заасан байдаг.

³⁴ Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны иргэн Жаргалсайхантай хийсэн ярилцлагын судалгаанаас.

³⁵ <http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/>

³⁶ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт <http://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2012 оны 12 сард “**Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх НҮБ-ийн зарчим ба удирдамж**”-ийг баталсан нь хууль зүйн туслалцаа үзүүлэх талаар олон улсын төвшинд гаргасан анхны дэвшилтэт баримт бичиг болсон юм. Дэлхийн улс орнууд үндэсний төвшинд хууль зүйн туслалцаа үзүүлэх талаар дотоодын хуулиараа зохицуулсан байдаг ч олон улсын энэхүү зарчмыг заавал баримтлах үүрэгтэй.

Энэхүү олон улсын баримт бичиг нь дараах 5 ойлголтыг чухалчилсан байдаг.

1. Хууль зүйн туслалцаа авах ерөнхий шалгуур. Зарчмын 3-т заахдаа улс орнууд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ тухайн хэрэг ээдрээ түвэгтэй эсвэл оногдуулах ял нь цаазаар авах зэрэг онц хүнд ял оногдуулахаар бол тухайн этгээдийн хөрөнгө чинээг харгалзахгүй байх. Өөрөөр хэлбэл, өөрсдөө төлж чадахгүй тохиолдолд зөвхөн хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлнэ гэж ойлгохгүй байхыг заажээ.³⁷

2. Паралегал болон бусад хууль зүйн туслалцаа үзүүлэгчид. Энэхүү баримт бичиг нь паралегалыг хууль зүйн туслалцаа үзүүлэх нэг хэлбэр болохыг хүлээн зөвшөөрсөн анхны олон улсын баримт бичиг юм. Паралегал гэдэг нь хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс бусад чиглэлээр эрх зүйн туслалцаа³⁸ үзүүлэх чадвартай, тусгайлан бэлтгэгдсэн этгээдийг хэлнэ.³⁹ Зарчим 14-т хувийн хуульчдын нийгэмлэг, холбоо, их дээд сургууль, иргэний нийгэм болон бусад институтийг хууль зүйн туслалцаа үзүүлэхэд хувь нэмрээ оруулах ажлыг хөхүүлэн дэмжих ёстойг тунхаглажээ.

3. Хүйсийн мэдрэмжтэй байх. Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудалд хүйсийн үүрэг чухал болохыг энэхүү баримт бичигт онцолжээ. Тухайлбал, Удирдамжийн 9-д “хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой бүхий л бодлогын асуудал, хууль эрх зүй, процессын ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдэд хүйсийн чиг хандлагыг анхаарах, хүйсийн тэгш байдлыг хангах нь ихээхэн чухал юм. Улс орнууд хэрвээ боломжтой бол эмэгтэй хуульчид ижил хүйсийн сэжигтэн, яллагдагч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг заажээ.

4. Эрүүгийн хэргийн гэрч, хохирогч. Эрүүгийн хэрэгт хохирогч, гэрчийн эрх болон хэрэгцээ шаардлагад тодорхой анхаарал тавих нь зүйтэй. Зарчмын 4,5 –д улс орнууд зарим тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч, гэрчид хууль зүйн туслалцаа заавал үзүүлэхийг тогтоож өгсөн байна. Зохих шатанд нь эдгээр хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах нь дамжиггүй.

³⁷ Хүний Эрхийн Европын шүүх тухайлбал, зөвхөн өөрсдөө төлөх чадамжгүй хүмүүст үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжтой гэж үздэг.

³⁸ Эрх зүйн туслалцаа гэдэгт өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн туслалцаа, эрх зүйн зүйн сургалт, сурталчилгааг хамруулна.

³⁹ Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судалж, санал боловсруулах судалгааны ажлын тайлангаас <https://www.forum.mn/projects/HumanRight/Report%20on%20current%20legal%20aid%20delivery%2010%2004%2013%202003.pdf>

5. Эрх зүйн сургалт, сурталчилгаа. Зарчим ба удирдамжид иргэд хууль зүйн туслалцаа авах эрхээ мэддэг байх нь чухал болохыг онцолсон байна. Улс орон иргэдийнхээ эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхдээ тодорхой чиглэлээр сургалт сурталчилгаагаар хангах ба ингэхдээ орон нутгийн өөрөө удирдах байгууллага, боловсролын болон шашны байгууллагуудаар дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу интернэт, радио, телевизийн хөтөлбөр, үндэсний хэмжээний ба орон нутгийн сонин сэтгүүлийг ашиглан явуулах нь зүйтэйг зөвлөжээ.⁴⁰

2.2. Хууль зүйн туслалцаа үзүүлж буй гадаад орнуудын туршлага

Дэлхийн улс орнуудад иргэддээ хууль зүйн туслалцааг үзүүлэх, тэдгээрийн эрхийг хамгаалах асуудал нь чухал ач холбогдол бүхий байр суурийг эзэлдэг байна. Улс орнуудын өөрсдийн эрх зүйн бүл, тогтолцоо, онцлогт тохирсон арга хэрэгслээр хууль зүйн туслалцааг иргэддээ үзүүлдэг төдийгүй хууль зүйн туслалцааны эрх зүйн орчин, бүтэц, тогтолцоо ч өөр өөр байдаг. Ихэнхи улсад “хууль зүйн туслалцаа” буюу legal aids гэсэн нэр томъёо нь төлбөртэй хувийн өмгөөлөгчдийн үйлчилгээ гэхээсээ илүүтэйгээр төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх улсаас санхүүждэг үнэ төлбөргүй үйлчилгээ хэмээн ойлгогдож байна.⁴¹

Гадаадын улс орнуудад төлбөрийн чадваргүй иргэддээ хууль зүйн туслалцаа үзүүлэх практик өөр өөр бөгөөд зөвхөн өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр зогсохгүй өөрийн оронд хууль ёсоор амьдарч буй гадаадын иргэдэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг жишиг байна. Монгол Улс 2 талт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг /иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, худалдааны, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай/ 20 оронтой, 4 оронтой гэмт этгээдийг шилжүүлэх өгөх тухай гэрээ, 2 улстай ялтан шилжүүлэх тухай гэрээ⁴² тус тус байгуулжээ.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнүүдийн агуулгаас харахад Иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхэд гол төлөв нэхэмжлэл гаргах, шүүхийн зардлаас чөлөөлөгдөх, хэлэлцэн тохирогч нэг улсын нутаг дэвсгэр дээр нөгөө улсын тухайн асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх журам ажиллагааг зохицуулдаг бол эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр холбогдогч этгээдийн гэм буруугүйд тооцох зарчмын баталгаа, эрх зүйн туслалцаа авах эрх, гомдол гаргах эрх, эрх чөлөөг хангах⁴³ зэргийг голчлон зохицуулдаг байна.⁴⁴

⁴⁰ <https://www.opensocietyfoundations.org/fact-sheets/un-guidelines-and-principles-access-legal-aid-criminal-justice-systems>

⁴¹ Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч-гарын авлага, УБ, 2014 он, 70 дугаар тал.

⁴² Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас.

http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа_харилцан_үзүүлэх_нь.html.

⁴³ Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас.

http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа_харилцан_үзүүлэх_нь.html.

⁴⁴ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа, ХЗҮХ, 2017 он.

Гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалт, туршлагаас суралцах үүднээс 2 хөрш орон болох ОХУ, БНХАУ, “гуравдагч хөрш” гэгдэх болсон БНСУ болон Япон улсыг сонгон авч судаллаа.

2.2.1. БНХАУ болон ОХУ-ын эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй туршлага

БНХАУ-ын Хууль зүйн туслалцааны төв нь 1990 оны эхэн үед орон даяар тархсан цогц системгүй байсан ба 2003 онд бие даасан хууль батлагдсан. 1994 онд Хууль зүй яам "хууль зүйн туслалцааны төвийн" тогтолцоог бий болгох санал оруулж Засгийн газар бүрэн дэмжиж, энэхүү олон талт арга хэмжээг хөгжүүлэн авч хэрэгжүүлж эхэлсэн. 1996 онд Хууль зүйн Яамны тушаалаар бүх нутаг дэвсгэрт хууль зүйн туслалцааны төвүүдийг байгуулах болсон. 2015 онд төрийн зөвлөлийн ажлын тайланд "хууль зүйн туслалцааны төвийн хамрах хүрээ нь зөвхөн амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой иргэдэд үйлчилнэ" гэж заасан нь уг байгууллагын үйл ажиллагаа хэрэгтэй хүнд хүрч байхаар сайжруулсан.⁴⁵

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг иргэний болон эрүүгийн хэрэгт аль алинд нь үзүүлэх ба амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд түүнчлэн тусгай бүлгийн хүмүүс (Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүд, цагаач ажилчид, ажлаас халагдсан иргэд)-д үзүүлдэг байна. Эрүүгийн хэрэгт хараагүй, сонсголгүй зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цаазаар авах ял оногдуулах зүйлээр яллагдаж буй яллагдагч нь эдийн засгийн байдал үл харгалзан хууль зүйн туслалцаа авах эрхтэй байдаг бол иргэний хэрэг маргааны тухайд засгийн газрын нөхөн олговор, нийгмийн хамгаалалын болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр болон тэтгэмж, хүүхдийн тэтгэмжийн асуудлаар хязгаарладаг байна.⁴⁶

Хууль зүйн яамны харьяанд ажилладаг Хууль зүйн туслалцааны үндэсний төв нь нэхэмжлэгч, хохирогч талд шүүхийн өмнө өмгөөлөх үйлчилгээ үзүүлдэг ба хариуцагч, гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгдөг онцлогтой. Мөн Эмэгтэйчүүдийн холбоо, Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвүүд гэх мэт иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд дээрх байгууллага нь хууль зүйн туслалцаа авах өргөдөл хүлээн авч болдог. Харин хууль зүйн сургуулийн дэргэдэх клиник төвүүдэд хуулийн оюутан нар хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх байдлаар хамтран ажилладаг.

ОХУ-ын туршлагаас

2006 оноос ОХУ-д иргэдэд үнэ төлбөргүй иргэний эрх зүйн туслалцаа үзүүлэх ажил эхэлсэн байна. 2011 оны 11 дүгээр сард тус улсад “ОХУ-ын Хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийг баталж 2012 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон ба энэ хууль эрүүгийн хэрэг⁴⁷ бус зөвхөн иргэний хэрэг

⁴⁵ Хууль зүйн туслалцааны төвөөс хийсэн харьцуулсан судалгаанаас авч ашиглав.

⁴⁶ Мөн тэнд.

⁴⁷ Эрүүгийн хэрэгт холбогдох хууль зүйн туслалцааг ОХУ-ын Хуульчдын холбоо хэрэгжүүлсээр ирсэн.

маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль юм. Тус хуулиар үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх бүхий иргэдийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Амьжиргааны эх үүсвэрээс доогуур орлоготой иргэд. Муж болгонд өөр өөр байдлаар хэмжигдэх ба одоогийн хүн амын 10 хувиас илүүтэй нь энэ хэсэгт багтдаг байна.⁴⁸
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өнчин хүүхэд болон тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигч;
- Байнгын болон түр зуурын асаргаа хэрэгцээтэй ахмад настан;
- Баривчлах болон бусад арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй гэмт этгээд;
- Сэтгэцийн өвчтэй хүн;
- Эрх зүйн чадамжгүй этгээд ба түүний харгалзан дэмжигч.

Эдгээр иргэд нь аман зөвлөгөө болон бусад хууль зүйн туслалцааг дараах хэрэг дээр авах эрхтэй байдаг.

- Үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэг, бүртгэл,
- Амьжиргааны хэрэглээтэй холбоотой хэрэглэгчийн эрхийн асуудал
- Хөдөлмөрийн хэрэг маргаан
- Ажилгүйдэл, түүнтэй холбоотой тэтгэмжийн маргаан
- Ажлын байранд учирсан эрүүл мэндийн хохирол, гэмтэл, амь насаа алдах зэрэгтэй холбоотой асуудал
- Нийгмийн халамж, төрийн сангийн нийгмийн туслалцаа
- Тэтгэвэр, тэтгэмжийн маргаан
- Жирэмсэн, хүүхэд асрах болон хүүхдийн тэтгэмжтэй холбоотой маргаан
- Улс төрийн хэлмэгдэлтийн нөхөн төлбөр
- Эрх зүйн чадамжийг хязгаарласантай холбоотой асуудал
- Сэтгэцийн өвчтнийг дорд үзэх, ялгаварлах
- Засгийн газрын агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн албан тушаалтнаас гаргасан захиргааны актын талаарх хэрэг маргаан зэрэг.

Хууль зүйн туслалцааг хэрэгжүүлэхдээ мужууд дараах 2 загвараас сонгож хэрэглэнэ.

1. Цалинжсан хууль зүйн туслалцааг хэрэгжүүлэгч хуульчид- үүнийг “төрийн хуулийн ажилтан” гэж нэрлэх ба Хууль зүйн яамнаас санхүүжиж зохион байгуулагддаг.
2. Мужийн хуульчдын холбооноос томилогддог хувийн өмгөөлөгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ба мужийн төсвөөс санхүүждэг.

Тус улсын шинэ хуулиар “төрийн байгууллагын бус хууль зүйн туслалцааны тогтолцоо” гэсэн ойлголт орж ирсэн бөгөөд үүнд их дээд сургуулийн хуулийн клиникүүд болон төрийн бус байгууллага, хуульчид,

⁴⁸ <http://www.pilnet.org/public-interest-law-programs/legal-aid-reform/dimas-blog/137-russian-legal-aid-bill-signed-into-law.html>

хуульчдын холбооны өөрсдийн зардлаар байгуулсан төрийн бус хууль зүйн туслалцааны төвүүдийг багтаана. Хуулиар хууль зүйн туслалцаа үзүүлэгч төрийн болон төрийн бус төвийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлж, төрийн бус хууль зүйн төвүүдийн ажиллагааг аман зөвлөгөө болон хууль зүйн баримт бичгүүдийн эхийг бэлтгэж өгөх зэргээр хязгаарлаж түүнчлэн орон нутгийн Хууль зүйн яамны харьяа байгууллагад бүртгүүлж байхыг шаардсан байдаг. Холбооны Хууль зүйн яам нь бүх хууль зүйн туслалцааны төвүүдийг хамтын ажиллагааг удирдан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхээс гадна мониторинг хийж түүнчлэн ОХУ-ын хууль зүйн туслалцааны тогтолцооны талаарх жил бүрийн тайланг гаргадаг.

2.2.2.БНСУ, Япон улсын эрх зүйн орчин, практик

Япон улс 2004 оны 7 дугаар сарын 2-ны өдөр “Хууль зүйн туслалцааны тухай иж бүрэн хууль”-ийг баталсан ба үүний дараагаар Хууль зүйн туслалцааны төв байгуулагдсан. Иргэний болон эрүүгийн хэрэг маргааныг шийдвэрлэх явцад иргэдэд хэрэгцээтэй хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж чадах нийгмийг бүтээх зорилготойгоор түүнчлэн хуулийн хэрэгжилтийг мөрдүүлэх үүднээс ажилладаг байгууллага юм. Өөрөөр хэлбэл, шүүн таслах ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, үр нөлөөтэйгээр явуулахад туслалцаа үзүүлэх, иргэдийг өмгөөлөгч, хуулийн фирмүүд болон хуулийн шинжээч, мэргэжилтэнгүүдээс⁴⁹ эрх зүйн иж бүрэн туслалцаагаар шуурхай хангагдах ажлыг зохион байгуулна.

Япон улсад Хууль зүйн туслалцааны төв нь онлайнар болон утсаар өөрийн орны болон гадаадын иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг байна. Тухайлбал, утсаар хууль зүйн зөвлөгөө өгөх үнэ төлбөргүй утсан дээр англи, солонгос, хятад, испани, португал, вьетнам, филиппин зэрэг хэл дээр орчуулагч нар хэрэглэгчийн хүлээн авч хуульчтай холбон туслалцаа үзүүлдэг байна. Хууль зүйн зөвлөгөөг гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг гэр бүлийн хэрэг маргаан мөн ажлаас үндэслэлгүй халагдах, цалин хөлсөө олгохгүй байх зэрэг хөдөлмөрийн хэрэг маргаантай холбоотой асуудал, виза, осол аваарь, өр зээлтэй холбоотой асуудлаар нэн тэргүүн анхан шатны зөвлөгөөг өгдөг.

БНСУ нь өнөөг хүртэл олон төрлийн хууль зүйн туслалцааны тогтолцоог бий болгон хэрэгжүүлж байна. 1954 онд эрүүгийн байцаан шийтгэх хуулийн улсын өмгөөллийн тогтолцоо, 1960 онд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн шүүхийн туслалцааны тогтолцоог эхлээд хэрэгжүүлсэн бөгөөд цаашлаад 1982 онд “Өмгөөлөгчийн хууль”-д өмгөөлөгчдийн холбооны хууль зүйн туслалцаа, 1986 онд “Хууль зүйн туслалцааны хууль”-д БНСУ-ын хууль зүйн туслалцааны корпораци болон хууль зүйн туслалцааны хуулийн этгээдийн хэрэгжүүлж буй хууль зүйн туслалцааны тогтолцоо аажимдаа нэвтэрсэн.⁵⁰ 1986 онд “Хууль зүйн туслалцааны хууль”-ийг баталсан нь тухайн үеийн хууль зүйн туслалцаа идэвхигүй байсан нөхцөл байдлыг сайжруулан илүү систем, зохион

⁴⁹ Өмгөөлөгч, хуулийн фирмийн хуульчаар ажилладаггүй боловч хууль зүйн асуудал дээр иргэдийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд байна.

⁵⁰ Хууль зүйн туслалцааны төвөөс хийсэн харьцуулсан судалгаанаас авч ашиглав.

байгуулалттай хэрэгжүүлэхийн тулд хуульчилсан бөгөөд үүгээр БНСУ-ын хууль зүйн туслалцааны тогтолцоо илүү сайн хөгжиж чадсан. Тус улсад хууль зүйн туслалцаа хүссэн хэн бүхэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөөг ямарч байдлаар (биечлэн, утасаар, дүрс бичлэгээр, цахим шуудангаар) авч болдогоороо Япон улстай адил зохицуулалттай байна.⁵¹ Тус хуульд зааснаар Хууль зүйн туслалцааны корпорацийг байгуулсан ба энэ нь хуулийн этгээдийн статустай байна.⁵² Тус корпораци нь төлбөрийн чадваргүй, эрхээ хамгаалж чадахгүй байгаа хүмүүст хүрч үйлчилж улмаар хүний эрхийг хамгаалж, хууль зүйн туслалцааны тогтолцоонд хувь нэмрээ оруулах зорилгынхоо хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнд: 1. хууль зүйн туслалцаа, 2. хуулийн тусламжийн тогтолцоотой холбоотой судалгаа шинжилгээ, 3. хууль мөрдөх сэтгэлгээг дээшлүүлэх зорилготой соён гэгээрүүлэх үйл ажиллагаа буюу сургалт, сурталчилгаа, 4. түүнээс гадна корпорацийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагаа байна. Өөрөөр хэлбэл, БНСУ-ын хууль зүйн туслалцааны корпорацийн зорилтот үйл ажиллагаа нь хууль зүйн туслалцаанаас гадна хууль зүйн туслалцааны талаарх судалгаа, хууль сахих ухамсрыг иргэдэд төлөвшүүлэхэд шаардлагатай сургалтын үйл ажиллагаа болон бусад ажиллагаа зэргийг багтаадаг байна. Хууль зүйн туслалцаа гэдэгт хууль зүйн зөвлөгөө, шүүхэд төлөөлөх, үүнээс гадна хууль зүйн үйл ажиллагаатай холбоотой бүхий л туслалцаа хамаарна гэж заасан байдаг. Гэвч зөвхөн эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа авах эрхтэй этгээдүүдэд үнэ төлбөргүй үйлчилдэг бол иргэний хэрэгт гэрээ байгуулан шүүх хурлын дараа төлбөрийг уян хатан нөхцөлтэйгээр авсаны дараа хэрэг хаагддаг. Гэсэн хэдий ч ердийн өмгөөлөгчийн хөлснөөс бага байдаг.⁵³

Хууль зүйн туслалцааг хуулийн дагуу сарын дундаж орлого нь 2.600.00 воноос бага орлоготой дотоодын болон гадаадын иргэдийг хамруулсан ба бусад Азийн орнуудаас хамгийн өргөн цар хүрээг хамарч хууль зүйн туслалцааг үзүүлдэг онцлогтой юм.

ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ИРГЭНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦҮҮЛЭН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖООР ХАНГАХ НЬ

3.1. Монгол Улсад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал ба олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн орчинг сайжруулах буюу хуульд өөрчлөлт оруулах нь

Иргэддээ үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрхийг эдлүүлэх асуудал улс орны төрийн бодлогын нэн чухал асуудлын нэг тул Монгол Улс тусгай хууль батлуулан ХЗТТ байгуулан эрх зүйн орчин бүрдүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий боловч одоо хэрэгжиж байгаа тогтолцоонд олон улсын хэм

⁵¹ Мөн тэнд.

⁵² БНСУ-ын Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 8 болон 9 дүгээр зүйл.

⁵³ Хууль зүйн туслалцааны төвөөс хийсэн харьцуулсан судалгаанаас авч ашиглав.

хэмжээ, гадаадын улсуудын сайн жишигт нийцүүлэн сайжруулан хөгжүүлэх олон асуудлууд байсаар байна. Үүнд:

Хууль зүйн туслалцааны тухай ойлголт, цар хүрээ:

Хууль зүйн туслалцаа үзүүлж буй үндсэн эх сурвалж болох “Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль”-д⁵⁴ хууль зүйн туслалцаа нь 1. Хууль зүйн зөвлөгөө өгөх, 2. Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн 2 төрлөөр хязгаарлажээ. Тэгвэл олон улсад энэхүү ойлголт нь өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө, эрх зүйн мэргэжлийн сургалт, сурталчилгаа хамардаг байна.⁵⁵ Тэгвэл НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2012 оны 12 сард гаргасан Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх НҮБ-ийн зарчим ба удирдамжид “хууль зүйн туслалцаа гэдэгт баривчлагдсан, цагдан хоригдсон, хоригдсон этгээдэд түүнчлэн сэжигтэн, яллагдагчдад болон эрүүгийн хэргийн хохирогч, гэрчид үзүүлэх үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, туслалцааг хэлнэ. Цаашлаад хууль зүйн туслалцаа гэдэгт мөн эрх зүйн сургалтад хамруулах, эрх зүйн мэдээлэл хүргэх зэрэг бусад үйлчилгээг хамруулна” гэсэн байна.

БНСУ-д Хууль зүйн туслалцаа төв нь олон нийт, орон нутгийн явуулын төв, засан хүмүүжүүлэх газар, хөдөлмөрийн байгууллага гэх мэт газруудад хууль зүйн сургалт тогтвортой явуулдаг байна.

Хууль зүйн туслалцааны төв байгуулагдсан цагаас эхлэн сургалт, сурталчилгааны ажлыг орхигдуулаагүй нь сайшаалтай бөгөөд тухайлбал, “Хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл” сэдэвт сургалтыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх, Сүхбаатар дүүрэг, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь, Дорнод, Архангай, Өмнөговь аймаг, Дорноговь Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар, Хуулийн хэлтэс, Цагдаагийн газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулын сурагчид, политехникийн коллежийн оюутнууд болон иргэдэд зориулан 3 удаагийн давтамжтай зохион байгуулж нийт 1870 хүн хамруулсан байна. Мөн түүнчлэн “Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт хэрэг”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” болон “Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг” сэдэвт сургалтуудыг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, политехникийн коллежийн оюутнууд болон иргэдэд зориулан 3 удаагийн давтамжтай зохион байгуулж нийт 5591 хүн хамруулжээ.⁵⁶

Иймд цаашид хууль зүйн туслалцаа гэдэг ойлголтод хуульд заасан 2 төрлөөс гадна иргэдийг эрх зүйн сургалтад хамруулах, эрх зүйн мэдээлэл хүргэх

⁵⁴ Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.

⁵⁵ Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судалж, санал боловсруулах судалгааны ажлын тайлангаас (санал 9)

<https://www.forum.mn/projects/HumanRight/Report%20on%20current%20legal%20aid%20delivery%2010%2004%2013%202003.pdf>

⁵⁶ Хууль зүйн туслалцааны төвийн 2016 оны тайлангаас.

зэрэг бусад үйлчилгээг хамруулна өргөн цар хүрээгээр хуульчлах нь зүйтэй байна.

Хохирогч, гэрчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал:

“Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим ба удирдамж”-ийн 7 дугаар зүйлд зааснаар зохих зөвлөгөө, туслалцаа, халамж дэмжлэгийг гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нь улс орнуудын үүрэг бөгөөд энэ нь хохирогчийг хамгаалах, дахин хохирохоос сэргийлж буй хэрэг гэжээ. Насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах, түүнчлэн эрүүгийн хохирогчоос гадна иргэний хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа хэрэгцээтэй бол үзүүлэх ёстойг заасан байна.

Мөн БНСУ-ын хууль зүйн тогтолцоонд Хууль зүйн туслалцааны төв нь хууль зүйн туслалцааны явцад гэмт хэргийн хохирогчийн эрхийг зүй зохистойгоор хангаж хохирлыг нөхөн сэргээх болон гэмт хэргийн хохирогчийг хуулиар хамгаалах зэрэг дэмжлэг үзүүлэхийг ихээхэн чухалчилсан байдаг. Олон улсын баримт бичиг болон улс орнуудын туршлагаас үзэхэд хохирогч тэр тусмаа насанд хүрээгүй хохирогч, гэрчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг ихээхэн чухалчилсан байна.⁵⁷

Олон улсын болон гадаадын сайн жишиг бүхий улсын туршлагаас үзэхэд хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх нь зайлшгүй Монгол Улсын хууль зүйн туслалцааны тогтолцоонд нэвтрүүлэх хэрэгцээт асуудлын нэг болжээ.

Паралегал болон бусад хууль зүйн туслалцаа үзүүлэгчид:

Энэ ойлголт нь хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө болон өмгөөллийн үйчилгээнээс бусад чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх чадвартай этгээдийг хэлдэг.⁵⁸ Иймд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульчдын ачааллыг бууруулах үүднээс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд паралегалчдын үйл ажиллагааг дэмжих шаардлагатай. Малави улс хорих байгууллагад үйл ажиллагаа явуулдаг паралегалын үйлчилгээний туршлагыг нэвтрүүлсэн нь амжилттай хэрэгжин Бангладеш, Кени, Нигер, Уганда зэрэг Африкийн бусад улсуудад ч загвар болж байна.⁵⁹ Паралегал үйчилгээ үзүүлэх талаар НҮБ-ын баримт бичигт улс орнууд өөрсдийн үндэсний хууль тогтоомжоор паралегал болон бусад хууль зүйн туслалцаа үзүүлэгчдийн хуульчдын эрэлт хэрэгцээ бүхий газарт хууль зүйн туслалцаа үзүүлж буй үүрэг ролийг буюу нийгэмд гүйцэтгэх ач тусыг хүлээн зөвшөөрч, дэмжих шаардлагатайг заасан байдаг.⁶⁰ Ингэхдээ паралегал үйчилгээ үзүүлэх этгээдүүдийг иргэний нийгмийн болон хууль, шүүхийн зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авах нь зүйтэйг анхааруулсан:

⁵⁷ “Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим ба удирдамжийн 48 дугаар зүйл.

⁵⁸ <https://www.forum.mn/projects/HumanRight/Report%20on%20current%20legal%20aid%20delivery%2010%2004%2013%202003.pdf>

⁵⁹ “Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч” гарын авлага, УБ, 2014 он, 76 дахь тал.

⁶⁰ Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим ба удирдамжийн 67 дугаар зүйл.

1. Тодорхой стандарт бүхий хөтөлбөртэй сургалтын тогтолцоо, түүнчлэн магадлан итгэмжлэх, хянах шалгах механизм бүхий тогтолцоог бий болгож паралегал үйлчилгээний үндэсний тогтолцоог улс орон даяар бүрдүүлж, чадавхижуулах;
2. Паралегал үйлчилгээний стандарт чанарын баталгааг хангах үүднээс мэргэжлийн хуульчдын хяналтан дор тохирох сургалтуудад паралегал үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулах;
3. Паралегал үйлчилгээг чанар, хүртээмжтэй байлгах үүднээс үнэлгээний болон хяналтын механизмаар хангах;
4. Паралегал үйлчилгээ үзүүлэгчдийн хууль зүйн туслалцааны төрөл болон зөвхөн мэргэжлийн хуульчид үзүүлэх хууль зүйн туслалцааны төрлүүдийг тус тус тодорхой тогтоох,
5. Цагдаагийн хэсэг, хорих анги, цагдан хорих төвүүд болон бусад байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэхээр томилогдсон паралегал үйлчилгээ үзүүлэгчид нь магадлан итгэмжлэл авсан байх;
6. Мэргэшсэн паралегал үйлчилгээ үзүүлэгч нь мэргэжлийн хуульч оролцуулах боломжгүй тохиолдолд шүүхийн процесст оролцох болон яллагдагчид зөвлөгөө үзүүлэх зэргийг үндэсний хууль тогтоомжоороо хуульчлах.

Дээрх хандлагаас суралцан паралегал үйлчилгээг Монгол Улсын хууль зүйн туслалцааны тогтолцоонд нэвтрүүлэх, ялангуяа хорих ангиудад паралегал үйлчилгээ ихээхэн шаардлагатай байна. Нийт хорих ангид ял эдэлж байгаа ялтны 47.8 хувь нь дахин гэмт хэрэг үйлдээд хорих ангид буцаад орж ирсэн ялтан байдаг гэсэн тоон мэдээ байдаг. Энэ нь хорих ангиас суллагдсан этгээдэд нийгэмшүүлэх болон хууль зүйн мэдээлэл, туслалцааны үйл ажиллагаа маш сул байдагтай холбоотой.

Про боно үйл ажиллагааг дэмжих:

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд⁶¹ “хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа гэж хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилготой аливаа үйл ажиллагааг ойлгоно” гэж, мөн 5 дугаар зүйлд “хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг сайн дураараа явуулахыг эрмэлзэнэ.” гэж тус тус заасан байдаг нь Монгол Улсын про боно үйл ажиллагааны эрх зүйн суурь үндэс юм.

Про-боно нь олон улсад төлбөрийн чадваргүй иргэнд хуульчийн хувьд үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн үйлчилгээ байдаг. Pro bono нь 19 дүгээр зууны эцсээр АНУ-д бий болсон ба Америкийн хуульчын холбоо нь 1983 онд Холбооны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлахдаа энэхүү дүрмийн 6.1 зүйлд өмгөөлөгч нь үнэ төлбөргүй хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд доод тал нь өөрийн ажлын цагийн 2 хувийг зарцуулах ёстой гэж заасан.⁶² Түүнчлэн

⁶¹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.1.6

⁶² http://apuo.mpro.ru/bup/index.php?page=3_social

Европод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг 13 дугаар зуунаас үзүүлж байсан ба тухайлбал, Францын өмгөөлөгчдийн холбоо (гильд) нь өмгөөлөгчдийг хөрөнгө чинээгүй ядуу иргэдэд туслахыг үүрэг болгож шүүх хуралд оролцохдоо төрийн дэмжлэгтэй хөтөлбөрийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлдэг байжээ.

Өмнөд Солонгост хуульчид pro bono үйл ажиллагаанд доод тал нь 30 цаг зарцуулдаг, орон нутгийн өмгөөлөгчдийн хувьд 20 цаг хүртэл багасгаж болдог байна. Энэхүү шаардлагыг биелүүлж чадахгүй байгаа өмгөөлөгч нь нэг цагт ₩20,000–30,000 (\$17-26)-той тэнцэх хэмжээний төлбөр төлөх үүрэгтэй байна.⁶³

Монголын Хуульчдын холбооны анхдугаар Их Хурлын 9 дүгээр тогтоолоор батлагдсан Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн хурлын 2013 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам”, Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн хурлын 2014 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журам”-д хуульчийн зүгээс сайн дурын үндсэн дээр, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний талаар тодорхой зохицуулсан. Энэ нь про боно үйлчилгээг Монгол Улсад бэхжүүлэн хөгжүүлж олон улсын жишигт хүргэх сайн талтай.

⁶³ Мөн тэнд.

ДУГНЭЛТ

Монгол Улсад Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 55 дугаар зүйлд тус тус заасны дагуу төр иргэдэд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хуульчилжээ. Мөн олон улсын үндсэн баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, Хүүхдийн эрхийн конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц зэрэг гэрээ конвенциуд түүнчлэн Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх НҮБ-ийн зарчим ба удирдамжид аливаа улс орон иргэддээ хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэйг заасан байдаг.

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээ, конвенцид зааснаар төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцааг алагчлалгүйгээр үзүүлэх, иргэн хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг тусган бэхжүүлсэн байна. Хэдийгээр төлбөрийн чадваргүй иргэн бүрд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нь улс орны санхүү эдийн засаг, хуульчдын хүний нөөцийн хувьд хүндрэл тохиолдох боловч иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх буюу хууль зүйн туслалцаа зайлшгүй шаардагдах зорилтот бүлэгт хүргэх нь төрийн үүрэг билээ. Монгол Улс албан ёсны хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн үндсэн тогтолцоотой болж ХЗТТ-ийг байгуулснаар түүнчлэн Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдсанаар гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй яллагдагч хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломж нээгдэж энэхүү хууль амжилттай хэрэгжиж байгаа бидний судалгааны явцад харагдаж байна. Гэсэн хэдий ч зөвхөн гэмт хэргийн яллагдагч бус үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах бусад нийгмийн зорилтот бүлгүүдийн бодитой эрэлт хэрэгцээ манай нийгэмд байсаар байгаа ч хуулийн хязгаарласан зохицуулалттай холбоотойгоор төлбөрийн чадваргүй хохирогч, иргэний, захиргааны хэрэг маргааны оролцогчид хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжгүй буюу нийгмийн зорилтот бүлэгт энэ үйлчилгээ бүрэн хүрэхгүй байгаа нь харагдаж байна.

Дэлхийн бусад орнуудад зөвхөн эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэхээр явцууруулан хэрэглэдэггүй нь бидний 2 дугаар бүлэгт хийсэн судалгааны үр дүнгээс харж болох юм. Тухайлбал, Австрали (нийгмийн даатгал, зээл, сэтгэцийн эрүүл мэнд, гэмтэл, цагаачлал болон дүрвэгч, асран хамгаалалт болон ялгаварлан гадуурхалтын эсрэг асуудалд), Канад (гэр бүлийн хэрэг маргаан), БНХАУ, Молдав, ӨАБНУ, Япон, ОХУ зэрэг орнуудад эрүүгийн болон иргэний хэрэг маргаанд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлдэг бол БНСУ-д эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа авах эрхтэй этгээдүүдэд шууд үнэ төлбөргүй үйлчилж, иргэний хэрэгт тодорхой шалгуур бүхий иргэнтэй шүүх хурлын дараа төлбөрийг уян хатан нөхцөлтэйгээр авах болзолтойгоор гэрээ байгуулан хууль зүйн туслалцаа үзүүлэх нь бий. Гэсэн хэдий ч энэ төлбөр нь хувийн өмгөөлөгчийн хөлснөөс бага байдаг. Иймд хууль зүйн туслалцааг үнэ

төлбөргүй үзүүлэх хэргийн харьяалалыг өргөжүүлэх, ингэхдээ иргэний тодорхой төрлийн хэрэг маргаан байвал зохилтой.

Бидний судалгааны үндсэн зорилго болсон үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд хэрэгцээт нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлох үүднээс хийгдсэн санал асуулгын, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын түүнчлэн харьцуулсан судалгааны үр дүнд нийгмийн халамж шаардсан эмзэг бүлгийн гишүүд буюу хөгжлийн бэрхшээлтэй хүн, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг, эх, орон гэргүй тэнэмэл амьдралтай хүн, 18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсэн 18-24 насны этгээд, өрхийн амжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн-иргэн, хорих ангиас суллагдсан ажилгүй, орон гэргүй этгээд зэрэг нь хамгийн өндөр хувьтайгаар нэгдүгээр зэргийн зорилтот бүлэгт хамрагдах шаардлагатай байна. Түүнчлэн эрүүгийн хэргийн хохирогч (ялангуяа бэлгийн болон гэр бүлгийн хүчирхийллийн хохирогч)-д хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа ихээхэн хэрэгцээтэй байгаа нь улсын өмгөөлөгч болон хуулийн байгууллагын ажилтнуудын саналаас харагдлаа.

Эцэст нь Монгол Улсад эрх зүйн орчин бүрэлдэн үйл ажиллагаа нь тогтворжин амжилттай эхлэл нь тавигдсан энэхүү хууль зүйн туслалцааны тогтолцоог улам батжуулан бэхжүүлж, зорилтот бүлгийн цар хүрээг өргөжүүлэх, хүний нөөцийг өргөжүүлэн тогтворжуулах, чадавхижуулах, иргэдэд эрх зүйн сургалт сурталчилгааг улам өгөөжтэй хүртээх олон асуудлууд байсаар байгааг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэх өөрөөр хэлбэл, тус хуулийг шинэчлэн найруулах цаг болсон нь тус судалгаагаар батлагдаж байна. Үүнд, хууль зүйн туслалцаа хэмээх ойлголтыг одоогийн хуульд заасан хууль зүйн зөвлөгөө, өмгөөлллийн туслалцаа гэсэн 2 төрлөөс өргөжүүлж олон улсын хэмжээнд нийцүүлэн эрх зүйн сургалт, сурталчилгаа гэсэн том ойлголттой нь цугт нь хуульчлах, зөвхөн эрүүгийн хэрэгт бус бусад хэрэг маргааны төрлийг хамруулах, нийгмийн зорилтот бүлгийг өргөжүүлэх, түүнчлэн хууль зүйн туслалцаа үзүүлэх улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох зэргээр олон асуудлуудыг хөндөх цаг хэдийн болжээ.

Дээрх асуудлуудыг нарийвчлан тодорхойлж, эрх зүйн зохицуулалт хийх боломжийг эрэлхийлсний үндсэн дээр дараах 10 саналыг зөвлөмжлөв.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

САНАЛ 1. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн цар хүрээг өргөжүүлж эрүүгийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч төдийгүй хохирогч гэрчийг хамруулах түүнчлэн иргэний болон захиргааны зарим төрлийн хэрэг маргааныг тодорхой хязгаартайгаар хамруулах. Үүнд: тэтгэлэг гаргуулахтай холбогдсон зарим төрлийн иргэний хэрэг маргаан, гэр бүлийн болон хөдөлмөрийн маргаан, өмч хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгч зэрэгт хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх шаардлагатай. Түүнчлэн дээрх хуулийн нэршлийг хамрах хүрээг даган, “Хууль зүйн туслалцааны тухай хууль” гэж өөрчлөх нь зүйтэй.

САНАЛ 2. Цалинтай орон тооны өмгөөлөгчөөс гадна шаардлагатай тохиолдолд хувиараа өмгөөлөл хийдэг хуульчдад төлбөр төлөн ажиллуулдаг Австрали зэрэг орны туршлага байна. Иймд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч нараас гадна ХЗТТ зохион байгуулан МХХ-ны гишүүн өмгөөлөгч нартай гэрээ хийн үйлчилгээнд шаардагдах зардлыг төрөөс хариуцах байдлаар хууль зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоог хуульчлах. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг зөвхөн төр дангаар хариуцах бус мэргэжлийн холбоодыг татан оролцуулж, хамтран ажиллавал асуудлыг зардал багатай, үр өгөөжтэйгөөр шийдвэрлэх ба одоо байгаа тогтолцооны хүрээнд төлбөрийн чадваргүй яллагдагч дээр төлбөрийн чадваргүй сэжигтэн /шүүгдэгч, ялтан/, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг нэмж, бусад маргааны оролцогчдод мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, өмгөөлөгч нар хууль зүйн туслалцаа үзүүлдэг байж болох юм гэсэн судлаачийн дүгнэлттэй санал нэг байна.⁶⁴ Ингэхдээ ХЗТТ-д суурилсан мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр бусад байгууллага, өмгөөлөгчид хамтран ажиллах шаардлагатай.

САНАЛ 3. Хууль зүйн туслалцааг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татагдсан тэр үеэс эхлэн үзүүлдэг байх нь хүний эрхийг хангах хамгийн том үзүүлэлт болно. Учир нь цагдан хоригдох, мөрдөн байцаах явцад хүний эрхэнд халдаж, эрх нь зөрчигдөх, эрүүдэн болон бусад хууль бус хэлбэрээр шүүгдэх явдал дэлхийн улс орнуудад хамгийн анхаарал татдаг. Иймээс ихэнх хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд энэ талаар онцгой анхаарал хандуулдаг. Эрүүгийн хэрэгт аль болох эрт шатнаас хууль зүйн, өмгөөллийн туслалцаа үзүүлэх нь тэр хүний эрхийг хангахад төдий чинээ өндөр үр нөлөөтэй байх нь тодорхой юм. Шинээр батлагдан 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх ЭХХШТХ-иар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч томилон оруулцуулахтай холбоотой зохицуулалтыг хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хэргийн оролцогчийн эрхийг хангах, тэдэнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах боломжийг олгоход чиглэгдсэнээр ихээхэн шинэлэг зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй этгээдэд

⁶⁴ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааны тайлан, ХЗҮХ, 2017 он.

өмгөөлөгчийг томилохдоо яллагдагчаар татагдсан цагаас бус эрүүгийн хэргийн бүхий л үе шатанд мөн мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд оролцуулах гэсэн 2 тодорхой зүйл заалтыг хуульчлан өгсөн хүний эрхийг хангах томоохон баталгаа болжээ.⁶⁵ Иймд шинээр батлагдсан ЭХХШТХ-ийн зохих заалтуудын хэрэгжих үндэс нь энэхүү хуулийн цар хүрээг өргөжүүлэн өөрчлөн шинэчлэх шаардлагатайг зөвлөмжилж байна.

САНАЛ 4. Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг хүртэх нийгмийн зорилтот бүлгийг хуулинд өргөжүүлэх нэмж хуульчлах. Өөрөөр хэлбэл, нийгмийн халамж шаардсан эмзэг бүлгийн гишүүд болох өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг, эх, орон гэргүй тэнэмэл амьдралтай хүн, 18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчирсэн 18-24 насны этгээд, өрхийн амжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн гишүүн-иргэн, хорих ангиас суллагдсан ажилгүй, орон гэргүй этгээд зэргээр хуулийн үйлчилгээг хүртэх этгээдийн хүрээг өргөжүүлэн энэхүү үйлчилгээг эрэлт хэрэгцээт нийгмийн бүлэг рүү улам түлхүү чиглүүлэх саналтай байна. Хууль зүйн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур тодорхой нийгмийн зорилтот бүлгүүдэд үзүүлэхээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны эд хөрөнгөө алдах эрсдэлт байгаа иргэн, ахмад настан, улс орондоо гавьяат үйлс бүтээсэн иргэд зэргээр хууль зүйн туслалцаа хүртэх гавьяатай болон эрхтэй бүлгийг иргэний, захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаанд хамруулах.

САНАЛ 5. Төрөөс улсын өмгөөлөгчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, түүний эрх зүйн байдлыг тодорхой болгох нь одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хийдлийг арилгах, тус төвд чадварлаг өмгөөлөгчид ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Иймд улсын өмгөөлөгчийн статусыг төрийн албан тушаалтны зохих ангилалд оруулж, цалингийн жишгийг шинэчлэн тогтоох, төрийн албан хаагчийн ахуй хангамжаар хангах шаардлагатай.

САНАЛ 6. Паралегал үйлчилгээг нэвтрүүлж, хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө болон өмгөөллийн үйчилгээнээс бусад чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх чадвартай этгээдийн үйл ажиллагааг хуульчлан дэмжих шаардлагатай. Ингэснээр үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульчдын ачааллыг бууруулах боломжтой. Ялангуяа паралегал болон бусад хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчдийг хорих ангид ажиллуулдаг олон улсын жишгийг нэвтрүүлэх.

САНАЛ 7. Олон улсын хэмжээнд хууль зүйн туслалцааны нэг төрөлд тооцогддог хууль зүйн сургалт, мэдээлэл сурталчилгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар ХЗТТ болон бусад байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх байдлаар өргөжүүлэн ажиллах шаардлагатай. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль зүйн сургалт, сурталчилгааг тогтмол явуулж байх төдийгүй улсын өмгөөлөгч болон ХЗТТ-ийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд тогтмол сурталчлах шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдлаа.

⁶⁵ ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйлийн 2, 18.1 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

САНАЛ 8. МХХ өмгөөлөгчдийг жилд 1 удаа үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ явуулах ажлыг зохион байгуулж, пробоно үйл ажиллагааг дэмжих, сайн дурын өмгөөлөлийн туслалцаа үзүүлж байгаа хуульчдад тодорхой дэмжлэг үзүүлж⁶⁶ хамтран ажиллах нь зүйтэй. Санал 2-д дурдсанаар жилд 1 удаагаас дээш про боно үйл ажиллагаа явуулсан өмгөөлөгч ХЗТТ-тэй гэрээ байгуулан ажиллах ба тухайн өмгөөлөгчид тодорхой хэмжээний⁶⁷ ажлын хөлсийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын 87 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журмын 1.2. дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар төрөөс санхүүжүүлж олгодог байх тогтолцоог хуульчлах нь зүйтэй.

САНАЛ 9. Монгол Улс гэмт хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг Монгол улсын хууль тогтоомжоос гадна олон улсын гэрээ, конвенциор хүлээдэг. Түүнчлэн ЭБШХ болон ЭХШШТХ-ийн зохих заалтуудад⁶⁸ өмгөөлөгч заавал оролцуулах субъектэд монгол хэл, бичиг мэдэхгүй хүн гэсэн байдаг нь гадаадын иргэн, харьяалалгүй монгол хэл, бичиг мэдэхгүй этгээдийг өмгөөлөгчөөр хангах үүргийг прокурор, шүүхэд хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалт билээ. Иймд дээр дурдагдсан этгээдэд хууль зүйн туслалцаа авах боломж бүхий эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зөвлөмжилж байна.

САНАЛ 10. Монгол Улсын Эрүүгийн хууль(шинэчилсэн найруулга)-д шинээр анх удаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт хуульчлагдлаа. Үүнтэй холбоотойгоор хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа зайлшгүй шаардлагатай төлбөрийн чадваргүй буюу дампуурсан, татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан⁶⁹ хуулийн этгээдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх талаар эрх зүйн харилцааг зохицуулах шаардлага тулгарч байгааг анхаарах шаардлагатай.

⁶⁶ Тодорхой дэмжлэг гэдэгт кредит цагийн төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх урамшуулал байж болох саналыг МХХ-ны ажилтантай хийсэн ярилцлаганд дурдсан болно. 2017 оны 5 сар.

⁶⁷ Бага хөлсөөр үзүүлэх нь зүйтэй. Судлаач.

⁶⁸ ЭБШХ-ийн 40.1 болон ЭХШШТХ-ийн 5.3 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг.

⁶⁹ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр буюу 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар татан буулгах албадлагын арга хэмжээ оногдуулахаар хуульчилсан. <http://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1966 он
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он
4. Хүүхдийн эрхийн конвенц, 1990 он
5. НҮБ-ын Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд хууль зүйн туслалцаа үзүүлэх зарчим ба удирдамж, 2012 он
6. ОХУ-ын Хууль зүйн туслалцааны тухай хууль, 2012 он
7. БНСУ-ын Хууль зүйн туслалцааны тухай хууль
8. Япон улсын Хууль зүйн туслалцааны тухай иж бүрэн хууль, 2004 он
9. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль 2013 он
10. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль 2002 он
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015 он
12. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 он
13. Зөрчлийн тухай хууль, 2015 он
14. Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, 2015 он
15. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр 2006 он
16. Хууль зүйн туслалцааны төвийн дүрэм 2014 он
17. Монголын хуульчдын холбооны дүрэм, 2013 он
18. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, 2014 он
19. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журам, 2014 он
20. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам, 2014 он
21. Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар А/15 тоот тушаал. Босго шугам тогтоох тухай
22. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам. 2014 он
23. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал 2011 он.
24. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 он
25. Елена Бурмицкая “Эрүүгийн хэрэгт хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх дэлхийн загварууд”, 2009 он
26. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааны тайлан, ХЗҮХ, 2017 он
27. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж судалгаа. Хууль зүйн туслалцааны төв. УБ., 2016 он
28. Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судалж, санал боловсруулах судалгааны ажлын тайлан, 2010 он

29. Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн “Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн гарын авлага. УБ., 2013
30. Хууль зүйн туслалцааны төвийн захиралтай хийсэн ярилцлага /2017 оны 4 дугаар сарын 25-ны өдөр/
31. Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлага /2017 оны 4 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг болон Төв аймгийн ХЗТТ-ийн салбаруудад очиж ярилцлагын судалгаа явуулсан/
32. Иргэдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, /2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэдээс санамсаргүй түүвэрлэн тус ярилцлагыг зохион байгуулсан/.
33. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл. 2016 он
34. Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох хүснэгт /Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль/. 2016 он
35. Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. УБ., 2016 он
36. Хууль зүйн туслалцааны төвийн 2014 оны жилийн эцсийн ажлын тайлан.
37. Хууль зүйн туслалцааны төвийн 2015 оны жилийн эцсийн ажлын тайлан.
38. Хууль зүйн туслалцааны төвийн 2016 оны жилийн эцсийн ажлын тайлан.
39. Монголын хуульчдын холбооны цахим хуудас
40. “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” Статистикийн Үндэсний хороо, Дэлхийн банк. УБ., 2014 он
41. Монголын Хуульчдын холбооны 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 2/170 тоот албан бичиг
42. Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Хуульчдын холбооны 2014-2015 онд хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн нийт тоон үзүүлэлт
43. Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас. <http://mojha.gov.mn/>
44. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн цахим хуудас <http://www.legalinfo.mn/law/>